



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-НИЙ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/113/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Нямтөмөр
Утас: 261740 Цахим хаяг: nyamtumurl@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :Аккаунт траст аудит ХХК
Захирал П.Наранцэцэг
Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
5.1 Шилэн дансны мэдээлэл	11
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
7. Аудитын илрүүлэлт	12
7.1 Залруулсан алдаа	12
7.2 Төлбөрийн акт	12
7.3 Зөвлөмж	12
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДЭХ	Дулааны эрчим хүч
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТЗБАХ	Техник зохион байгуулалтын арга хэмжээ
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/563
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ЦАНЛИГРЭНЧИН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Засгийн газраас авах айл өрх, аж ахуйн нэгжийн цахилгааны төлбөрийг төр хариуцах дулаан эрчим хүчний төлбөрийн 384.6 сая төгрөгийн авлага барагдаагүйгээс өр төлбөр барагдуулах боломжгүй болсон байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Эрчим хүчний сайдын 2021 оны 1/27 дүгээр тушаалаар Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 5,735.8 сая төгрөг, нийт зардлыг 6,510.0 сая төгрөг, үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээг 233.9 сая төгрөг, алдагдлыг 774.2 сая төгрөг байхаар баталсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 22 дугаар тогтоолоор нийт орлогыг 6,095.8 сая, зардлыг 6,681.8 сая, алдагдлыг 585.9 сая төгрөгөөр тодотгосон байна. Гүйцэтгэлээр 6,310.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,501.9 сая төгрөгийн зардал гарган, 191.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 7 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	29,033,245.62	17,396,771.33
1.1.2	Дансны авлага	1,003,413,755.03	579,224,192.69
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	157,302.11	56,609.22
1.1.4	Бусад авлага	-	5,309,527.27
1.1.6	Бараа материал	972,922,126.56	638,024,193.42
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,005,526,429.32	1,240,011,293.93
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	33,050,118,568.42	31,936,871,076.54
1.2.2	Биет бус хөрөнгө	504,333,197.32	498,164,958.93
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	33,554,451,765.74	32,435,036,035.47
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	35,559,978,195.06	33,675,047,329.40
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,571,065,324.01	829,919,524.07
2.1.1.3	Татварын өр	273,601,294.57	190,960,040.85
2.1.1.5	Богино хугацаат зээл	500,000,000.00	400,000,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	21,947,711.00	11,456,050.66
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,366,614,329.58	1,432,335,615.58
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,366,614,329.58	1,432,335,615.58
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	33,981,526,313.42	33,981,526,313.42
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,155,701,953.17	3,155,701,953.17
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	462,450,000.00	462,450,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(4,406,314,401.11)	(5,356,966,552.77)
2.3.11	Эздийн өмчийн дүн	33,193,363,865.48	32,242,711,713.82
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	35,559,978,195.06	33,675,047,329.40

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,463,372,507.84	6,244,957,884.64
2	Борлуулалтын өртөг	5,849,041,058.53	5,787,472,672.44
3	Нийт ашиг (алдагдал)	(385,668,550.69)	457,485,212.20
5	Хүүгийн орлого	2,003,484.90	
8	Бусад орлого	113,754,941.08	65,727,580.87
9	Борлуулалт, маркетингийн зардал	220,678,637.06	224,243,853.90
10	Ерөнхий ба удирдлагын зардал	164,449,259.52	176,659,817.90
11	Санхүүгийн зардал	67,443,265.17	78,045,479.44
12	Бусад зардал	141,484,641.45	235,519,411.67
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(38,528,939.34)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(902,494,867.25)	(191,255,769.84)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(902,494,867.25)	(191,255,769.84)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.42	3,155,701,953.17	469,600,866.64	(2,965,245,498.91)	34,641,583,634.32
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(538,574,034.95)	(538,574,034.95)
Залруулсан үлдэгдэл	33,981,526,313.42	3,155,701,953.17	469,600,866.64	(3,503,819,533.86)	34,103,009,599.37
Өмчид гаргасан өөрчлөлт			(7,150,866.64)		(7,150,866.64)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(902,494,867.25)	(902,494,867.25)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.42	3,155,701,953.17	462,450,000.00	(4,406,314,401.11)	33,193,363,865.48
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(759,396,381.82)	(759,396,381.82)
Залруулсан үлдэгдэл	33,981,526,313.42	3,155,701,953.17	462,450,000.00	(5,165,710,782.93)	32,433,967,483.66
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(191,255,769.84)	(191,255,769.84)
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.42	3,155,701,953.17	462,450,000.00	(5,356,966,552.77)	32,242,711,713.82

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,893,402,630.87	6,669,819,821.56
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	5,815,704,621.26	6,614,160,018.21
1.1.4	Буцаан авсан албан татвар	1,161,784.16	4,094,854.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	76,536,225.45	51,564,949.35
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,670,788,530.10	6,282,390,362.30
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,361,707,123.08	1,287,693,978.50
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	499,773,751.47	477,107,987.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,672,677,458.78	1,670,402,545.28
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	632,247,267.00	498,978,075.28
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,075,926,198.66	1,592,602,280.54
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	67,443,265.17	78,045,479.44
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	325,890,550.45	551,243,372.94
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	800,000.00	8,012,080.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	34,322,915.49	118,304,563.32
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	222,614,100.77	387,429,459.26
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,003,484.90	5,000,000.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	5,000,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,003,484.90	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	171,304,461.81	304,065,933.55
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	171,304,461.81	304,065,933.55
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(169,300,976.91)	(299,065,933.55)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,195,006,708.00	400,000,000.00

3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,195,006,708.00	400,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,245,006,708.00	500,000,000.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	1,245,006,708.00	500,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(50,000,000.00)	(100,000,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,313,123.86	(11,636,474.29)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,720,121.76	29,033,245.62
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,033,245.62	17,396,771.33

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд		Хэмжих нэгж х	2020 оны Гүйцэтгэл 1	2021 он			
					Төлөвлөгөө 2	Гүйцэтгэл 3	Зөрүү 4=3-2	Хувь 5=3/2
1	Үйлдвэрлэх	ДЭХ	мян.Гкал	80,701.5	81,671.3	81,086.0	(585.3)	99.3
	Дотоод хэрэгцээний ДЭХ-ний зарцуулалт	хувиар	хувь	1.0%	1.3%	1.3%	-	100.0
		биетээр	мян.Гкал	1,061.7	1,061.7	1,037.0	(24.7)	97.7
	Түгээх	ДЭХ	мян.Гкал	79,639.8	80,609.6	80,049.0	(560.6)	99.3
2	Нийт орлого		сая.төг	5,579.1	6,095.8	6,310.7	214.9	103.5
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	5,463.4	6,072.6	6,244.96	172.4	102.8
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	115.8	23.2	65.7	42.5	282.9
3	Нийт зардал		сая.төг	6,481.6	6,681.8	6,501.9	(179.8)	97.3
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	6,123.2	6,603.6	6,419.9	(183.7)	97.2
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	358.4	78.1	82.1	3.9	105.0
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая.төг	(902.5)	(585.9)	(191.3)	394.7	32.6
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая.төг	(902.5)	(585.9)	(191.3)	394.7	32.6
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1.2	1.1	1.0	(0.1)	94.0
7	Нийт авлага		сая.төг	1,003.4	160.3	584.6	424.3	364.7
8	Нийт өглөг		сая.төг	2,366.6	2,120.0	1,432.3	(687.7)	67.6
9	Нийт ажиллагсад		тоо	154	135.0	135.0	-	100.0
10	Нийт цалингийн сан		сая.төг	1,809.3	1,779.4	1,633.4	(146.0)	91.8
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт		гр/Гкал	207.8	228.0	216.0	(12.0)	94.7
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая.төг	467.8	233.9	233.9	-	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтыг бүрдүүлэх, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгөд биет үзлэг шалгалт хийн, цаашид ашиглагдах хугацаа болон шинэчлэн тогтоох үнийн саналыг боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 10-аас 2022 он 03 дугаар сарын 15-ны хооронд Аккаунт траст аудит ХХК-ийн аудитор Б.Эрдэнэчимэг, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Д.Цэцэгсүрэн, захирал П.Наранцэцэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 82 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг гүйцэтгэх захирлын 2019 оны 06 дугаар сарын 01-ний А/68 тоот тушаалаар баталсан ба холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ТУЗ-ийн дотоод аудит 2021 онд тус компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 6,443.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 64.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн зорилго нь тухайн нутаг дэвсгэртээ хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай, бүрэн ханган, эдийн засгийн үр ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллахад оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хувьцаат компани статустай, өмчийн 100.0 хувийг төр эзэмшиж байгаа бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ЗГ-аас эрх олгосны дагуу Эрчим хүчний яам 70.0 хувийг, ТӨБЗГ 30.0 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Хөвсгөл дулааны станц ТӨХК нь 2014 онд “Дулааны станц шугам сүлжээний ашиглалтын өмнөх захиргаа” ТӨААТҮГ нэртэйгээр анх байгуулагдаж, ЗГ-ын 2016 оны 10 дугаар тогтоолоор ТӨХК болон өөрчлөгдөн байгуулагдсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй, 9 дүгээр зүйлийн 5 хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн удирдлагыг ТУЗ, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Эрчим хүчний сайд томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1 “ төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эрх барих дээд байгууллагын хуралд төрийг төлөөлөх этгээдийг уг хурлаар хэлэлцэх асуудал бүрээр өгөх саналын удирдамжийн хамт төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд томилж” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин, урамшууллыг дунджаар 0.5 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, ЗГ-ын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно, цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

ЗГ-ын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Эрчим хүчний яамнаас өгсөн чиглэлийн дагуу цахим үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цалин орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өглөг авлагыг бууруулах, компанийн үйлдвэрлэлийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, алдагдлыг бууруулахаар ТЭЗҮ, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан, батлуулсан байна.

ЗГ-ын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т заасны дагуу ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор бүтцийн өөрчлөлт хийж орон тоог 20 нэгжээр бууруулсан, тэтгэвэрт гарсан болон өөрийн хүсэлтээр ажлаас гарсан 5 ажилтны оронд шинээр томилгоо хийгээгүй, цалин, түүнтэй адилтгах зардлыг 159.6 сая төгрөгөөр хэмнэсэн, байгууллагын болон салбарын хэмжээний сургалтууд, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг цахимаар зохион байгуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр тушаалын 2-р хавсралт "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам", 3-р хавсралт "Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлал"
- Эрчим хүчний сайдын 2020 оны 269 дугаар тушаал “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам”
- Засгийн газрын 2021 оны 207 дугаар тогтоол “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”
- Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоол “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 463 дугаар тогтоол “Тариф батлах тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Өөрчлөлт	
Б	1	2	Дүн/3=2-1/	Хувь
Мөнгөн хөрөнгө	29,033.2	17,396.8	(11,636.4)	(40.1)
Авлага	1,003,571.1	584,590.3	(418,980.8)	(41.7)
Бараа материал	972,922.1	638,024.2	(334,897.9)	(34.4)
Үндсэн хөрөнгө	33,050,118.6	31,925,284.2	(1,124,834.4)	(3.4)

Биет бусад хөрөнгө	504,333.2	498,164.9	(6,168.3)	(1.2)
Нийт хөрөнгийн дүн	35,559,978.2	33,663,460.4	(1,896,517.8)	(5.3)
Богино хугацаат өр төлбөр	2,366,614.3	1,432,335.6	(934,278.7)	(39.5)
Эздийн өмч	33,193,363.9	32,231,124.8	(962,239.1)	(2.9)
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	35,559,978.2	33,663,460.4	(1,896,517.8)	(5.3)

Касс дахь бэлэн мөнгө 14.2 сая төгрөг, банк дахь харилцах дансанд 3.1 сая төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэлд дансны авлага 579.2 сая төгрөг, НДШ-ийн авлага 0.1 сая төгрөг, Засгийн газрын усны хөнгөлөлтийн авлага 5.3 сая төгрөг, нийт 584.6 сая төгрөгийн авлага байна.

Дансны авлагын үлдэгдлийн 66.4 хувь буюу 384.6 сая төгрөг ЗГ-аас авах авлага, 22.0 хувь буюу 127.1 сая төгрөг төсөвт байгууллагаас, 2.8 хувь буюу 16.5 сая төгрөг ААНБ-аас, 3.5 хувь буюу 20.4 сая төгрөг иргэдээс авах борлуулалтын авлага, 5.3 хувь буюу 30.6 сая төгрөг бусад авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 638.0 сая төгрөг болж 334.9 сая төгрөгөөр буурсан ба өөрийн хөрөнгөөр худалдан авсан 2,332.3 сая төгрөг, зарцуулсан 2,666.9 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө их засвар, ТЗБАХ-ний ажлын үр дүнд бий болсон 72.8 сая, худалдан авсан 169.4 сая, бараа материалаас үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн 4.5 сая, нийт 246.6 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 498.2 сая төгрөг болж 6.2 сая төгрөгөөр буурсан тайлант оны хорогдол байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд дансны өглөг 829.9 сая төгрөг, татварын өр 191.0 сая төгрөг, богино хугацаат зээл 400.0 сая төгрөг, урьдчилж орсон орлого 11.5 сая төгрөг, нийт 1,432.3 сая төгрөгийн өр төлбөр байна.

Дансны өглөгийн үлдэгдлийн 23.9 хувь буюу 198.0 сая төгрөг бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх өглөг, 34.4 хувь буюу 285.8 сая төгрөг ашиглалтын зардлын, 6.3 хувь буюу 52.6 сая төгрөг нүүрс тээврийн, 14.8 хувь буюу 123.2 сая төгрөг сэлбэг хэрэгслийн, 20.0 хувь буюу 165.9 сая төгрөг үндсэн хөрөнгө худалдан авснаас үүссэн өр төлбөр байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу дулаан дамжуулах өртөг, дулаан үйлдвэрлэлийн өртөг, борлуулалт маркетингийн зардал, ерөнхий удирдлагын зардал, бусад зардал гэж ангилсан байна.

Нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад 58.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөгт цалин, НДШ, томилолт, үндсэн хөрөнгийн элэгдэл, ашиглалтын зардал, урсгал засвар, санхүүгийн зардал, нүүрс тээвэр, бичиг хэрэг, үнс нурам зөөх, нүүрс түрэх, шатахуун, тосолгооны материал, ус, нүүрс, засвар үйлчилгээ, төсөвт төлсөн татварууд, хор саармагжуулах хүнс, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй бусад зардал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, байгаль орчныг хамгаалах, галын аюулаас хамгаалах, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, цэвэрлэгээ, сургалтын зардлуудыг хамруулсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3 заасны дагуу Хөвсгөл дулааны станц ТӨХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний сайдын 2021 оны 1/27 дугаар тушаалаар Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2021 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 5,735.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 6,510.0 сая төгрөгөөр, үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 233.9 сая төгрөгөөр, алдагдлыг 774.2 сая төгрөгөөр баталсан байна.

ТУЗ-ийн 2021 оны 22 дугаар тогтоолоор нийт орлогыг 360.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 6,095.8 сая, нийт зардлыг 171.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 6,681.8 сая, алдагдлыг 188.3 сая төгрөгөөр бууруулан 585.9 сая төгрөгөөр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр 6,310.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,501.9 сая төгрөгийн зардал гарган, 191.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, төлөвлөснөөс алдагдлыг 394.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 6,310.7 сая төгрөг болж төлөвлөснөөс 214.9 сая төгрөг буюу 3.5 хувиар давсан нь ЭХЗХ-ны 2021 оны 463 дугаар тогтоолоор шинэчлэн тогтоосон үнэ тарифыг 2021 оны 11,12 дугаар сард мөрдсөнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 6,501.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 179.9 сая төгрөг буюу 2.7 хувийн дутуу гүйцэтгэлтэй байгаа нь цалин, НДШ-ийн зардал, сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардал, шатахуун, томилолтын зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Их засварын 2, ТЗБАХ-ийн 10, хөрөнгө оруулалтын 14, урсгал засварын 33, нийт 59 ажлын нийт 233.9 сая төгрөгийн зардлыг өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл дулааны станц ТӨХК нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах нийт 6,564.1 сая төгрөгийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 47.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 31.4 сая төгрөгийг залруулж, 15.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар үргэлжлүүлэн авч үзсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 40.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт
/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	6.3	1	6.3	-	-	100
Зөвлөмж	2	40.9	2	40.9	-	-	100
Нийт дүн	2	47.2	2	47.2	-	-	100

7. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 74.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11.6 сая төгрөгийн алдааг залруулж, 16.8 сая төгрөгийн зөрчилд акт тогтоож, 45.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 62.7 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 64.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 1.7 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

7.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд дуусаагүй барилгад 11.6 сая төгрөгийн элэгдэл байгуулж, зардал илүү илэрхийлсэн алдааг залруулсан.

7.2 Төлбөрийн акт

Хөвсгөл аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар магадлалаар компанийн ТУЗ-өөс нэр бүхий иргэнд ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговор 16.8 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсний дагуу байгууллагаас олгосныг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ аваагүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

7.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант оны 4,376.8 сая төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 8 ААНБ-аас худалдан авсан 30.2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ и-баримтыг бүрдүүлээгүй, татварын цахим системийн баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Бараа ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтыг бүрдүүлж, татварын цахим системийн баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлэх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

ТӨБЗГ-ын 2019 оны 562 тоот тогтоолоор Дулааны 4 дүгээр цахилгаан станц ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн 2 ширхэг 15.7 сая төгрөгийн дансны үнэтэй авто тээврийн хэрэгслийг Хөвсгөл дулааны станц ТӨХК-д шилжүүлснийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн ч биетээр хүлээн аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.1 “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт; ...” гэсэн заалттай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Дулааны 4 дүгээр цахилгаан станц ТӨХК-аас 2 тээврийн хэрэгслийг хүлээн авч, акт үйлдэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Хөвсгөл дулааны станц ТӨХК	АХГ-2022/113/НА-СТА-ТӨА	Дуусаагүй барилгад 11.6 сая төгрөгийн элэгдэл байгуулж, зардал илүү илэрхийлсэн.		1	11,586.9	1.0	11,586.9								
2	Хөвсгөл дулааны станц ТӨХК	АХГ-2022/113/НА-СТА-ТӨА	Хөвсгөл аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар магадлалаар компанийн ТУЗ-өөс Б.Мөнхсайханд ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговор 16.8 сая төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсний дагуу байгууллагаас олгосныг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.	Шүүхийн шийдвэрээр ажилтанд олгосон нөхөн олговорд төлсөн нийт 16,809.3 мянган төгрөгийн төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлэх арга хэмжээ авах	1	16,809.3			1	16,809.3						
3	Хөвсгөл дулааны станц ТӨХК	АХГ-2022/113/НА-СТА-ТӨА	Тайлант оны 4,376.8 сая төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 8 ААНБ-аас худалдан авсан 30.2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ и-баримтыг бүрдүүлээгүй, татварын цахим системийн баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.	Бараа ажил үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэхдээ цахим и-баримтыг бүрдүүлж, татварын цахим системийн баримтын шивэлтэд хяналт хэрэгжүүлэх.		30,212.1								1	30,212.1	

4	Хөвсгөл дулааны станц ТӨХК	АХГ-2022/113/НА-СТА-ТӨА	ТӨБЗГ-ын 2019.12.16-ны өдрийн 562 тоот тогтоолоор Дулааны 4-р цахилгаан станц ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн 2 ш автомашин(Галын машин АЦ-40 Зил 130, Суудлын автомашин Фургон УАЗ -39094)-ыг Хөвсгөл дулааны станц ТӨХК-д балансаас баланст шилжүүлснийг ҮХ-ийн дансанд бүртгэсэн ч биетээр хүлээн аваагүй байна. /2 машины анхны өртөг 15,668.6 мян.төг/	Дулааны 4 дүгээр цахилгаан станц ТӨХК-аас 2 тээврийн хэрэгслийг хүлээн авч, акт үйлдэх.	1	15,668.6									1	15,668.6
ДҮН					3	74,276.9	1.0	11,586.9	1	16,809.3	-	-	-	-	2	45,880.7
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
ДҮН																
НИЙТ ДҮН					3	74,276.9	1.0	11,586.9	1	16,809.3	-	-	-	-	2	45,880.7



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 77/АО150055
АХГ-2022/113/НА-СТА-ТБА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, зорилтод түвшний гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 07 дугаар магадлалаар компанийн ТУЗ-өөс нэр бүхий иргэнд 16,809,270.00 төгрөгийн ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговрыг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилгүй байсан хугацааны олговорт олгосон 16,809,270.00 /арван зургаан сая найман зуун есөн мянга хоёр зуун далан/ төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Цанлигрэнчин, нягтлан бодогч В.Мөнгөнцэцэг нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АККАУНТ ТРАСТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
П.НАРАНЦЭЦЭГ